



ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ  
АЖИЛЛАГААНЫ ГАЗАР**

Б корпус, Засгийн газрын IX байр,  
Энхтайваны өргөн чөлөө 16, Баянзүрх дүүрэг,  
Улаанбаатар хот, 13381  
Утас/Факс: (976-51) 26 00 62  
Цахим шуудан: info@spa.gov.mn  
Цахим хуудас: www.spa.gov.mn

2023.12.27 № А - 1/4419  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Тодруулга хүргүүлэх тухай**

Тус газраас 2023 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр зарласан БХБЯ/202310021 дугаартай "Шинэ Хархорум хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулахад шаардагдах байрзүйн зураг зохиох эхний ээлжийн ажил /Архангай, Өвөрхангай/" төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтад оролцохыг сонирхогч этгээдээс ирүүлсэн тодруулгад дараах хариуг хүргүүлж байна.

Тодруулга	Хариулт
<p>1.Ажлын даалгаврын 3.2.1-д "Эхний ээлж - 92,000 га талбайд" гэж заасан боловч Ажлын даалгаврын 6.3-д Агаар мандлаас зураг авах хэмжээг 1893,63 км.кв талбайд гэж зөрүүтэй талбайн хэмжээг заасан байгааг тодруулж өгнө үү.</p> <p>2.Ажлын даалгаврын 7.2-д "Геодезийн сүлжээ байгуулах" хэсэгт "Монгол улсын GPS -ийн тулгуур болон үндсэн сүлжээнд тулгуурлан А ангиллын 1-р зэргийн сүлжээ байгуулна." гэж заасан байна. Ийм ангилал байдаггүй бөгөөд А ангилал, эсвэл Зураглалын сүлжээний 1-р зэргийн аль нь болохыг тодруулж өгнө үү.</p>	<p>1.Ажлын даалгаврын "Хамрах хүрээ" гэсэн 3 дахь хэсгийн 2.1-д заасан эхний ээлжийн 92,000 га талбай гэдгийг ойлгоно. Энэхүү талбайд "Агаар мандлаас зураг авах, сансрын зураг худалдан авах" талбайг ойлгоно. Ажлын даалгаврын "Ажлын үе шат" гэсэн 6 дахь хэсгийн 3 дахь заалтад заасан "1,893,863 км.кв" нь зураглахаар төлөвлөсөн нийт талбайн хэмжээ.</p> <p>2.Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 212 дугаар тушаалын хавсралт "Хиймэл дагуулын технологиор Монгол Улсын геодезийн сүлжээ байгуулах үндсэн дүрэм" /БНБД 11-13-22/ барилгын норм дүрмийн төслийн 1 дүгээр хүснэгтэд заасны дагуу /<a href="https://legalinfo.mn/mn/detail?lawId=16532033236861&amp;showType=1/">https://legalinfo.mn/mn/detail?lawId=16532033236861&amp;showType=1/</a> энэхүү сүлжээ нь идэвхгүй ангилалын А ангилалын сүлжээ гэж ойлгоно.</p>

1323214693

<p>Тендерийн өгөгдлийн хүснэгтийн ТӨЗ 4.4.4 дэх заалтанд төслийн удирдагч нь “Агаарын зураглалын инженер, агаарын зураглалын инженерээр ажилласан туршлагатай байх /Зөвлөх инженерийн зэрэгтэй /” гэсэн шалгуур тавьсан байна.</p> <p>Үүнд “Агаарын зураглалын инженер” /энэ мэргэжлээр Монгол улсын Их, дээд сургуулиудад мэргэжилтэн бэлтгэдэггүй/ мэргэжилтэй зөвлөх инженерийн оронд “Агаарын зураглал, боловсруулалтын хүрээнд” зөвлөх инженерийн зэрэг авсан “Геодезийн инженер” мэргэжилтэй хүн, эсвэл “Агаарын зураглалын инженер”-ээр ажилласан туршлагатай Геодезийн хэмжилт, зураглалын хүрээнд “Зөвлөх инженер” мэргэжилтэй хүн байж болох, эсэх талаар тодруулга өгнө үү.</p>	<p>Агаарын зураглалын зөвлөх инженер нь зөвлөх багийг удирдахаар уг зөвлөх үйлчилгээний ажлын ТББ-ийн ТӨХ-ийн 4.4.4 дэх заалтад тусгагдсан нь уг ажлын гол шалгуур үзүүлэлт бөгөөд уг ажлыг гүйцэтгэх бусад инженерүүдэд агаарын зураглалын инженер гэж тусгайлан заагаагүй тул уг ажилд геодезийн инженер болон мэргэшсэн инженерийн зэрэгтэй баг оролцох бүрэн боломжтой гэж үзсэн. Энэхүү ажлыг зөвхөн нэг хүнээр хязгаарлаагүй баг болон түншилж орж ирэх боломжийг нээсэн. Энэхүү ажил нь цаг хугацааны хувьд хязгаарлагдмал бөгөөд агаарын зураглалын технологи ашиглан байр зүйн зураг авах ажлыг байр зүйн зураг хийх шаардлага хангасан нисэх төхөөрөмжийг ашиглан хийж гүйцэтгэхээр төлөвлөгдсөн.</p> <p>Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 123 дугаар тушаалаар батлагдсан “Геодези, зураг зүйн ажлын жишиг үнэ” /БД 81-103-21/ барилгын дүрмийн 9 дүгээр бүлэг “ Байр зүйн зураглал”-ын 9.1 “Агаарын зураглалын төлөвлөгөө боловсруулах” хэсгийн “Багийн бүрэлдэхүүн”-д тавигдаж буй шаардлагад “Агаарын зураглалын мэргэшсэн /зөвлөх/ инженер” гэж заасан байдаг. Энэхүү зөвлөх үйлчилгээний ажил нь хот байгуулалтын суурь өгөгдөл, мэдээлэл, цаашид энэхүү ажлын үр дүнг ашиглан барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ, инженерийн дэд бүтцийн төлөвлөлтүүд хийгдэх тул төслийн багийн удирдагчийг “агаарын зураглалын зөвлөх инженер” байхаар сонгосон.</p>
<p>Дээрхи тендерийн баримт бичигт Тендерийн өгөгдөлийн хүснэгтийн ТӨЗ 4.4.4-т мэргэжил боловсрол дээр “Агаарын зураглалын инженер, агаарын зураглалын инженерээр ажилласан туршлагатай байх /Зөвлөх инженерийн зэрэгтэй /” гэсэн шаардлага тавьсан байна. Монгол улсад инженер бэлтгэж буй улсын сургуулиудад Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль, Хөдөө Аж Ахуйн Их Сургууль-д “агаарын зураглалын инженер” гэх бакалаврын зэргийн инженер бэлддэггүй, “геодезийн инженер, сансрын</p>	<p>Энэхүү нарийн мэргэжлийг ОХУ, ХБНГУ болон Монгол Улсын Политехникийн дээд дургуульд 1990 оноос өмнө болон дараа нь, харин Техникийн Их Сургууль /тухай үеийн нэрээр, одоогийн Монгол Улсын Шинжлэх ухаан, Технологийн Их сургууль/-д 1990 оноос бэлдэж эхэлсэн байдаг. Агаарын зураглалын инженерийг сүүлийн жилүүдэд мэргэжлийн багш, зөвлөх багш байхгүй гэдэг шалтгаанаар бэлдэж, төгсөхөө больсон хэдий ч Монгол улсад 20 гаруй агаарын зураглалын инженер байдаг.</p>

геодези” мэргэжлээр бакалаврын зэрэгт бэлддэг бөгөөд агаарын зураглалын инженерийг монгол улсад бэлтгэдэггүй, мөн зөвлөх инженерийн суурь бакалаврын зэрэг нь “Геодезийн инженер” мэргэжилд “Агаарын зураглалын хүрээнд” гэх тодотголтой гэрчилгээ олгодог тул дээрхи тендерийн баримт бичигт Тендерийн өгөгдөлийн хүснэгтийн ТӨЗ 4.4.4-т “мэргэжил боловсрол дээр Агаарын зураглалын инженер, агаарын зураглалын инженерээр ажилласан туршлагатай байх /Зөвлөх инженерийн зэрэгтэй /” гэсэн шаардлагыг “Геодезийн зөвлөх инженер”-р сольж өгнө үү.

Геодези, фотограмметр, зураг зүйн холбоо нь “фотограмметр” гэдэг үг хэллэгийг уг холбооны нэршилд оруулсан нь энэхүү технологийг эзэмшиж төгссөн, тус салбарт ажиллаж байгаа агаарын зураглалын инженерүүд байдаг гэдгийг нотолж байна.

Мөн түүнчлэн дээрх холбоо нь агаарын зураглалын мэргэшсэн болон зөвлөх инженерийн зэрэг горилох сургалтыг жилд 2 удаа зохион байгуулдаг. Агаарын зураглалын инженерээр төгссөн инженерүүд мэргэших боломжтой.

ДАРГА



Ц.БАТЗУЛ